## *ГАРЧИГ*

**БҮЛЭГ 1.** ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 2
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл ........ 2
1.2 Уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо, календарчилсан төлөвлөгөө ........ 3
1.3 Уурхайн хүчин чадал ........ 5
1.4 Ашиглалтын системийн сонголт ........ 5
1.5 1.2.3. Уурхайн ажлын горим, ажиллах хүчний тооцоо ........ 5
1.6 Ил уурхайн тоног төхөөрөмжийн сонголт ........ 6
1.7 Бутлан ангилж ялгах хэсэг ........ 6
1.8 Дэд бүтэц ........ 7
1.9 2025 оны жилийн хүчин чадал, ашиглах хугацаа ........ 8
**БҮЛЭГ 2.** ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 9
**БҮЛЭГ 3.** ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ........ 12
1.10 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим ........ 12
1.11 Төслийн гол сөрөг нөлөөллийг үнэлэх ........ 15
**БҮЛЭГ 4.** БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 19
1.12 Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ ........ 19
1.13 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ........ 20
1.14 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө ........ 27
1.15 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 28
1.16 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө ........ 28
1.17 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ........ 28
1.18 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ........ 29
1.19 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө ........ 31
1.20 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр ........ 32
1.21 Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ........ 34
1.22 Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө. ........ 34
**БҮЛЭГ 5.** БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ 36

# БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| ТӨСЛИЙН НЭР: | 2021/001А тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөх овоо” нэртэй дайргын орд |
| ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН НЭР: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ: РЕГИСТРИЙН ДУГААР: | **“**Гантулга трейд” ХХК, Монгол улсын 2010097 бүртгэлийн дугаартай, 9011535043 тоот аж ахуйн нэгжийн гэрчилгээ |
| ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ: | **:** Монгол улс, Дорноговь аймаг, Сайншанд сумын 2-р баг. Утас:22607, 99526048 |
| АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: | Дугаар: 2021/001А |
| ТӨСЛИЙН БАЙРШИЛ: | Төслийн талбай нь Улаанбаатар хотоос урагш 585 км, Сайншанд аймгийн төвөөс 140 км, Замын-Үүд сумаас баруун хойш 30 км-т байрлана. Тус орд нь байр зүйн зургийн К49-7-Б хавтгайд багтана. Уурхайн төв цэгийн солбицол нь уртрагийн 111°40'43.96"E", өргөргийн 43°52'17.59"N" байна. |

“Хөх овоо” нэртэй дайргын ордын талбай нь Дорноговь аймгийн Замын-Үүд, Эрдэнэ сумдын нутагт оршино. Төслийн талбай нь Улаанбаатар хотоос урагш 585 км, Сайншанд аймгийн төвөөс 140 км, Замын-Үүд сумаас баруун хойш 30 км-т байрлана. Тус орд нь байр зүйн зургийн К49-7-Б хавтгайд багтана. Уурхайн төв цэгийн солбицол нь уртрагийн 111°40'43.96"E", өргөргийн 43°52'17.59"N" байна.

*Хүснэгт 1. Талбайн солбицлын цэгүүд:*

| Тусгай зөвшөөрлийн дугаар | Талбай, га | Цэгийн дугаар | Уртраг (град, мин, сек) | Өргөрөг (град, мин, сек) |
|---|---|---|---|---|
| (2021/001А) | 26.03 | 1 | 111°40'54.43" | 43°52' 08.61" |
| | | 2 | 111°40'32.78" | 43°52' 08.61" |
| | | 3 | 111°40'32.78" | 43°52' 26.07" |
| | | 4 | 111°40'54.43" | 43°52' 26.07" |

*Зураг 1. Төслийн байршил*




## 1.2 УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦИЙН ТООЦОО, КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 2. “Хөх овоо” дайрганы ордын үйлдвэрлэлийн нөөц*

| **№** | **Ашиглалтын түвшин** | **1-р жил** | | **2-р жил** | | **3-р жил** | | **4-р жил** | | **5-р жил** | | **6-р жил** | | **7-р жил** | | **8-р жил** | | **9-р жил** | | **10-р жил** | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Хуулах хөрсний эзлэхүүн, мян.м$^3$** | **Ашигт малтмал олборлолт мян.м$^3$** | **Хуулах хөрсний эзлэхүүн, мян.м$^3$** | **Ашигт малтмал олборлолт мян.м$^3$** | **Хуулах хөрсний эзлэхүүн, мян.м$^3$** | **Ашигт малтмал олборлолт мян.м$^3$** | **Хуулах хөрсний эзлэхүүн, мян.м$^3$** | **Ашигт малтмал олборлолт мян.м$^3$** | **Хуулах хөрсний эзлэхүүн, мян.м$^3$** | **Ашигт малтмал олборлолт мян.м$^3$** | **Хуулах хөрсний эзлэхүүн, мян.м$^3$** | **Ашигт малтмал олборлолт мян.м$^3$** | **Хуулах хөрсний эзлэхүүн, мян.м$^3$** | **Ашигт малтмал олборлолт мян.м$^3$** | **Хуулах хөрсний эзлэхүүн, мян.м$^3$** | **Ашигт малтмал олборлолт мян.м$^3$** | **Хуулах хөрсний эзлэхүүн, мян.м$^3$** | **Ашигт малтмал олборлолт мян.м$^3$** | **Хуулах хөрсний эзлэхүүн, мян.м$^3$** | **Ашигт малтмал олборлолт мян.м$^3$** |
| 1 | 990 -> 995 | 17.5 | 8.79 | 8.79 | 4.4 | 9.48 | - | 12.6 | - | 10.8 | - | 9.48 | - | 7.04 | - | - | - | - | - | - | - |
| 2 | 985 -> 990 | 8.14 | 40.7 | 11.4 | 29.0 | 15.2 | 50.8 | 10.1 | 40.7 | 8.72 | 29.0 | 3.92 | 13.0 | 10.0 | - | 12.4 | - | - | - | - | - |
| 3 | 980 -> 985 | 3.29 | 41.1 | 7.28 | 41.1 | 4.11 | 41.1 | 3.65 | 36.5 | 3.65 | 36.5 | 9.86 | 54.8 | 7.28 | 41.1 | 6.47 | 36.5 | 12.6 | - | - | - |
| 4 | 975 -> 980 | 1.51 | 25.2 | 4.71 | 32.1 | 2.36 | 23.5 | 5.19 | 35.3 | 5.19 | 35.3 | 5.19 | 35.3 | 6.48 | 44.1 | 10.3 | 70.6 | 7.57 | 51.6 | 3.2 | - |
| 5 | 970 -> 975 | 0.12 | 23.1 | 0.16 | 28.8 | 0.23 | 23.1 | 0.12 | 21.6 | 0.19 | 34.6 | 0.19 | 34.6 | 0.23 | 43.3 | 0.21 | 38.5 | 0.37 | 69.3 | 0.0 | 29.3 |
| 6 | 965 -> 970 | 0.06 | 11.0 | 0.08 | 14.4 | 0.11 | 11.3 | 0.08 | 15.7 | 0.08 | 14.3 | 0.07 | 12.1 | 0.12 | 21.4 | 0.02 | 4.28 | 0.16 | 29.1 | 0.2 | 53.6 |
| **Нийт** | | **30.7** | **150** | **32.4** | **150** | **31.5** | **150** | **31.8** | **150** | **28.6** | **150** | **28.7** | **150** | **31.1** | **150** | **29.5** | **150** | **20.7** | **150** | **3.5** | **82.9** |
| **Кхх, м$^3$/м$^3$** | | **0.2** | | **0.22** | | **0.21** | | **0.21** | | **0.19** | | **0.19** | | **0.19** | | **0.2** | | **0.14** | | **0.04** | |

## 1.3 Уурхайн хүчин чадал

“Хөх-овоо” дайргын ордын талбай нь нам өндөрлөгт, тэгшивтэр гадаргуутай ил аргаар олборлоход хялбар орд юм. Ордын чулууг бутлахад гарах дайргын агуулга нь ордын дунджаар 99.63% байгаа нь авто замын хучаасны дайргын шаардлагыг хангаж байгаа ба стандартаар 90-100 байна.

## 1.4 Ашиглалтын системийн сонголт

Ордын хувьд хэвтээ хэвгий уналтай, уулын оройгоос бэл дагаж тогтсон, уул-техникийн ямар нэг хүндрэлгүй, ил аргаар олборлох боломжтой. Уурхайн хамгийн их гүн 36м, ашиглалтын явцад уурхайн гүн рүү ахих тул экскаватор болон автосамосвалын хослол бүхий авто тээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын системийг сонгон ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар сонгосон байна. Ордыг нөөцийг ашиглах үеийн хуулах хөрсний зузаан болон олборлох дайргын зузаан нь дараах хэмжээтэй байна. Үүнд:

- Шимт хөрсний зузаан – 0.2 м
- Хуулах хөрсний зузаан – 3.48м
- Олборлох дайргын давхаргын дундаж зузаан – 18.56 м

Шимт хөрсийг 0.2м зузаанаар хуулах ба дайрга олборлолтын ажлын доголын өндөр 5м байна. Уурхайн эцсийн хананд ажлын хоёр доголыг нэгтгэх буюу 10м өндөртэй доголоор хаана.

## 1.5 1.2.3. Уурхайн ажлын горим, ажиллах хүчний тооцоо

Уурхайн уулын ажил нь улирлын чанартай явагдах бөгөөд 10-р сарын 16-аас 4-р сарын 14-ийг хүртэл өвлийн улирлын сул зогсолт, олборлолтын үйл ажиллагаа 4-р сарын 15-аас 10 сарын 15-ыг хүртэл явагдах бөгөөд жилд 6 сар, нийт 10 жил ажиллах юм. Уурхайн ажиллах горимд үндэслэн тооцоход дайргын ордыг ашиглах ил уурхайн олборлолтын цагийн хүчин чадал 113.12 $м^3$/цаг, хоногийн хүчин чадал 961.5 $м^3$/хоног, жилийн хүчин чадал 150,000 $м^3$/жил байна.

*Хүснэгт 3. “Хөх овоо” дайрганы ордын ажиллах горим, хүчин чадал*

| № | Горимын үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Утга |
|---|---|---|---|
| 1 | Жилийн хуанлийн хоног | хоног | 365 |
| 2 | Өвлийн улирлын сул зогсолт | хоног | 181 |
| 3 | Жилийн ажиллах хуанлийн хоног | хоног | 184 |
| 4 | Баяр ёслолын амралт | хоног | 6 |
| 5 | Цаг агаарын саатал | хоног | 5 |
| 6 | Засвар үйлчилгээ | хоног | 10 |
| 7 | Бэлтгэл ажил | хоног | 7 |
| 8 | Уурхайн ажиллах хоног | хоног | 156 |
| 9 | Хоногт ажиллах ээлжийн тоо | ээлж | 1 |
| 10 | Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 10 |

| | | | |
|---|---|---|---|
| 11 | Цаг ашиглалтын итгэлцүүр | - | 0.85 |
| 12 | Нэг ээлж дэх цэвэр ажлын цаг | цаг | 8.5 |
| 13 | Хоногт ажиллах бодит цаг | цаг | 8.5 |
| 14 | Жилд ажиллах бодит цаг | цаг | 1326 |
| Дайргын ордыг ашиглах ил уурхай | | | |
| 15 | Уурхайн цагийн хүчин чадал | $м^3$/цаг | 113.12 |
| 16 | Уурхайн ээлжийн хүчин чадал | $м^3$/ээлж | 961.5 |
| 17 | Уурхайн хоногийн хүчин чадал | $м^3$/хоног | 961.5 |
| 18 | Уурхайн жилийн хүчин чадал | $м^3$/жил | 150000 |

## 1.6 Ил уурхайн тоног төхөөрөмжийн сонголт

“Хөх-Овоо” нэртэй дайргын ордыг дотоод овоолготой, авто тээвэр бүхий ил уурхайн аргаар ашиглах ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүдийг харгалзан ТЭЗҮ-д тусгасан.

*Хүснэгт 4. Тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны бүтэц, бүрэлдэхүүн*

| № | Ажил | Үйл ажиллагаа (тоног төхөөрөмж) | | |
|---|---|---|---|---|
| 1 | Шимт хөрс хуулалт | **Ухаж түрэх** | **Ухаж ачих** | **Тээвэрлэх** |
| | | Бульдозер | Утгуурт ачигч | Авто самосвал |
| 2 | Хөрс хуулалт | **Өрөмдлөг, тэсэлгээ** | **Ухаж ачих** | **Тээвэрлэх** |
| | | Өрмийн машин | Экскаватор | Авто самосвал |
| 3 | Дайрга олборлолт | **Өрөмдлөг, тэсэлгээ** | **Ухаж ачих** | **Тээвэрлэх** |
| | | Өрмийн машин | Экскаватор | Авто самосвал |




*Зураг 2. Уурхайн үндсэн үйл ажиллагааны бүтэц, бүрэлдэхүүн*

## 1.7 Бутлан ангилж ялгах хэсэг

Ордын хэмжээнд ашиглалтын жилүүдэд жилд дунджаар 150.0 мян.м3 дайрга бутлан, ангилж бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөсөн. Бутлан ангилах цех нь уурхайн үйл ажиллагаатай адил улирлын чанартай ажиллах бөгөөд 4-р сарын дундаас 10-р сарын дунд хүртэл бутлалт, шигшилтийн үйл ажиллагаа явагдах бөгөөд жилд нийтдээ 6 сар ажиллах юм. Бутлан, ангилах ажиллагаа нь хоногт 10 цагийн 1 ээлжээр ажиллах горимыг барина.

Бутлан, ангилах цех нь жилд нийтлээ 122 хоног буюу 1040 цаг ажиллах боломжтой юм. Хоногт 10 цагийн 1 ээлжээр ажиллах ба цаг ашиглалтын итгэлцүүр 0.85 байна гэж үзвэл хоногт нийт 8.5 цаг ажиллах юм.
Дайргын ордыг ашиглах уурхайн дайргын ширхэглэлийн шинжилгээнээс үзэхэд 0-5 мм ширхэглэлтэй хэсгийн гарц 7.01%, 5-10 мм-ийн ширхэглэлтэй хэсгийн гарц 87.84%, 10-20 мм-ийн ширхэглэлтэй хэсгийн гарц 5.15% байна.

*Хүснэгт 5. Бутлан ангилах хэсгийн ажлын горим*

| № | Горимын үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Утга |
|---|---|---|---|
| 1 | Уурхайн ажиллах хоног | хоног | 156 |
| 2 | Цехийн бэлтгэл ажил | хоног | 3 |
| 3 | Бутлан, ангилах цехийн ажиллах хоног | хоног | 153 |
| 4 | Цехийн тоног төхөөрөмжийн бэлэн байдлын итгэлцүүр | хоног | 0.8 |
| 5 | Бутлан, ангилах цехийн ажиллах бодит хоног | хоног | 122 |
| 6 | Хоногт ажиллах ээлжийн тоо | ээлж | 1 |
| 7 | Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 10 |
| 8 | Нэг ээлжин дэх цэвэр ажлын цаг | цаг | 8.5 |
| 9 | Цаг ашиглалтын итгэлцүүр | - | 0.85 |
| 10 | Хоногт ажиллах бодит цаг | цаг | 8.5 |
| 11 | Жилд ажиллах бодит цаг | цаг | 1040 |
| Дайрга бутлах, ангилах цехийн хүчин чадал | | | |
| 12 | Бутлан, ангилах цехийн цагийн хүчин чадал | $м^3$/цаг | 144.2 |
| 13 | Бутлан, ангилах цехийн хоногийн хүчин чадал | $м^3$/хоног | 1225.5 |
| 14 | Бутлан, ангилах цехийн жилийн хүчин чадал | $м^3$/жил | 150000.0 |

## 1.8 ДЭД БҮТЭЦ

### ***Цахилгаан хангамж***

“Хөх-Овоо” нэртэй дайргын ордыг ашиглах ил уурхайн хэсэг нь улирлын чанартай, нэг ээлжээр, өдрийн цагаар ажиллах учир цахилгааны хэрэглээ байхгүй. Үндсэн цахилгаан хэрэглэгчид нь ажилчдын хотхон, бутлан, ангилах цехийн цахилгаан төхөөрөмжүүд байх юм. Эдгээр цахилгаан хэрэглэгчдийг ордын талбайгаас 650 м зайд орших “Сайншанд-Замын-Үүд” чиглэлийн 35/0.4 кВ-ын агаарын шугамаас авахаар төлөвлөсөн.

Уурхайн хотхоны унд ахуйн хэрэглээний усан хангамжийн эх үүсвэрийг эхний байдлаар сумын төвөөс зөөврөөр шийднэ. Үйл ажиллагаа жигдэрч байнгын үйл ажиллагаа явуулах нөхцөлд уурхайн ойролцоох талбайд усан хангамжийн зориулалттай ашиглалтын худаг өрөмдөх замаар шийдвэрлэх боломжтой. Гэвч худаг өрөмдөх нөхцөлд усны судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэн, мөн сав газраас зөвлөмж авсны үндсэн дээр хийж гүйцэтгэх нь зөв юм. Төслийн талбай нь Галба-Өөш Долоодын говийн ай савд харьяалагдана.

1. Унд, ахуйн хэрэглээний ус
2. Уурхайн хэрэглээний ус
    - Ногоон байгууламжийн усалгаа
    - Замын усалгаа

Төслийн нийт 10 жилийн хугацаанд унд ахуйн ус хангамжид 7488 $м^3$ ус (0.06 л/с), зам усалгаанд 16,104.00 $м^3$ ус (0.12-0.18 л/с), ногоон байгууламжийн усалгаанд 20,456.80 $м^3$ ус (0.09-0.56 л/с) хэрэглэнэ. Төслийн нийт хугацаанд хэрэглэх усыг төслийн талбайд гаргасан гүний худгаас бүрэн хангана.

***Дулаан хангамж***

Уурхай нь улирлын чанартай, өөрөөр хэлбэл зөвхөн дулааны улиралд ажиллах тул тусгайлсан халаалтын систем шаардагдахгүй.

## 1.9 2025 ОНЫ ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АШИГЛАХ ХУГАЦАА

2025 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 150.0 мян.м3 дайрга олборлон борлуулахаар төлөвлөсөн.

# БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| № | Байгаль орчны бүрдэл | Товч тайлбар |
|---|---|---|
| 1 | Физик газарзүйн нөхцөл | Физик газарзүйн мужлалаар Говийн их мужид хамаарагдах ба Монголын дорнын их говиуд болох Галбын говь, Өөшийн говийн зүүн этгээдийн цав толгод, Говийн бэсрэг уулс бүхий хязгаар нутагт хамаарна. Ерөнхийдөө газрын гадаргуугийн 50-60% нь цав гүвээ, жижиг толгод бүхий тэгшивтэр тал нутаг байх ба үнэмлэхүй өндөр нь далайн түвшнээс дээш дунджаар 900-1100 м орчим өргөгдсөн байдаг байна. |
| 2 | Цаг уур уур амьсгал | Уур амьсгалын хувьд гандуу дулаан зунтай хүйтэн өвөлтэй байдаг байна. Хамгийн их хүйтрэлт нь 1-р сард -20...-25$^0$ хүрэх ба хамгийн халуун нь 7-р сард +35...+40$^0$ хүрнэ. Агаарын харьцангуй чийгшил дунджаар 40-50% байна. Ус чийг багатай тул манан будан ажиглагддаггүй байна.<br>Зуны улиралд түр зуурын бороо ордог. Үргэлжилсэн олон хоногийн бороо ордоггүй. Харин 2002 онд түр зуурын усархаг бороо олон удаа орж хуурай сайр хөндийнүүдээр үерлэж байсан байна. Өвөлдөө цас маш бага унадаг. Орсон цас нь түргэн зуур хайлдаг. Жилийн 4 улирал тогтмол салхитай байдаг байна. Салхины чиг нь ихэвчлэн баруун хойноос байх ба салхины хоногийн хэлбэлзэл ихтэй. Жилийн дунджаар авч үзвэл салхигүй өдрийн тоо 20-25 өдөр байдаг байна. Хамгийн их салхи хавар тохиолдох бөгөөд энэ үед цасан ба шороон шуурга шуурдаг байна. Жилийн салхины дундаж хурд 5-10 м/сек байна. Жилд дунджаар 32-39 хоног 15 м/сек хүртэл хүчтэй цасан ба шороон шуурга шуурдаг байна. |
| 3 | Агаарын чанар | Тусгай зөвшөөрлийн талбайн эргэн тойронд нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг тул агаарын бохирдол байхгүй харин уурхайн технологийн зам, ухаш, овоолго зэрэг нь тухайн орчинд тоосжилт үүсгэх нөхцөлтэй байна. |
| 4 | Гадаргын болон газрын доорх ус | “Хөх овоо” нэртэй дайргын ордын талбай нь Дорноговь аймгийн Эрдэнэ, Замын-Үүд сумын нутаг орших ба газрын гадаргын усны сүлжээний хувьд Галба-Өөш, Долоодын говийн сав газарт хамаарахаас гадна Төв азийн гадагш урсацгүй ай савд багтана. Галба-Өөш, Долоодын говийн сав газрын гадаргын усны нөөцийн үзүүлэлтээс харахад тус талбайн ус хурах талбай (км$^2$), урсцын модуль (л/с км$^2$), урсцын талбай (F) болон гадаргын усны ашиглах боломжит нөөц тус тус 0 нөөцтэй байна. Энэ ай савд хур тунадас харьцангуй бага, ууршилт их учраас гол мөрний сүлжээ маш бага байна. Мөн төслийн талбайн орчимд гол, горхи, булаг, нуур цөөрөм зэрэг ил задгай ус байхгүй. Галба-Өөш, Долоодын сав газрын энэ бүс нутагт жилдээ дунджаар 113.5 мм хур тунадас унадаг байна. |
| 5 | Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг | Говь хээрийн бор хөрсний бүслүүрт багтана. Хөрс үүсэхэд хур тунадас салхи ихээхэн үүрэгтэй. Салхи нь хөрсний агаарын солилцоог идэвхжүүлж ууршилтыг ихэсгэснээр хөрс хуурайшихад нөлөөлөөд зогсохгүй хөрсний өнгөн хэсгийг хийсгэж нүүлгэн хөрс эвдрэхэд ихээхэн нөлөөтэй байдаг байна. Талбайн хэмжээнд элсэнцэр бор хөрс, сайргархаг бор хөрс тус тус тархсан байна.<br>**Ургамал:** Монгол орны физик газарзүйн мужлалаар Төв Азийн заримдаг цөл, цөлийн их муж, Дорнод говийн муж, Хатанбулаг – Хөвсгөлийн нам уулсын дэд мужид хамааргадаж байна (Даш, |

| | | |
|---|---|---|
| | | 2002). Харин ургамал газарзүйн тойргоор Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарагдаж байна (Н.Өлзийхутаг 1989).<br>Монгол орны цөлийн хээр нь өвөрмөц, хээрийн бүсийн өмнөд хэсэгт цөлжүү хээр ба хээржүү цөлийн дунд өргөн зурвасыг үүсгэж, бие даасан ургамалжилтын бүсийг үүсгэдэг. Цөлийн хээр нь Төв Азийн унаган ургамал гэж А.А.Юнатов (1950) анх тэмдэглэж дараа нь энэ тухай нэгэн сэдэвт бүтээлдээ Юнатов (1974) дэлгэрэнгүй тусгасан байдаг. Цөлийн хээрийг зарим судлаачид заримдаг цөл (Келлер,1923, Прозоровский, 1940, Рачковская, 1989,1993, Волкова, 1994), нөгөө нь цөлөрхөг хээр (Даваажамц,1983, Өлзийхутаг, 1989) гэж нэрлэсэн ч эдгээр нь бүгд ижил ухагдахууныг илэрхийлж буй.<br>Цөлийн хээрийн тархац өдлөг хялгануудын (Stipa gobica, S.glareosa) харилцан адилгүй зонхилон тархаж буй газар нутгаар тодорхойлогдоно (Түвшинтогтох, 2014).А.А.Юнатов (1974) цөлийн хээрт Өдлөг хялгана, Зүүнгарын хазаар өвс, Таанаас гадна заримдаг сөөгөнцөр, сөөг зонхилсон бүлгэмдлийг хамруулан үзсэн байдаг. Цөлийн хээр ба цөлийн бүсийн заагнутгаар дэгнүүлт үетэн-заримдаг сөөгөнцөр (Salsola passerine, Anabasis brevifolia, Reaumuria soongorica)-т бүлгэмдэл өргөн тархаж Е.И. Рачков (1976), Е.М. Лавренко (1978), Е.А. Волкова (1992) нар цөлийн хээрт хамруулалгүй хээржүү цөлийн дэд бүс болгон ялгасан байдаг. |
| 5 | Амьтны аймаг | Ордын талбайд туурайтнаас хулан, аргаль, хар сүүлт, цагаан зээр, жижиг амьтдаас туулай байх ба махчин амьтдаас чоно, үнэг, хярс, шилүүс, мануул, илбэнх зэрэг амьтад нилээд тохиолддог байна. Хэвлээр явагчдаас могой, говийн гүрвэлүүд, мэрэгчдээс бозлог, алаг даага, оготно зэрэг амьтадтай. Жигүүртнээс тас, бүргэд, сар, элээ, хэрээ, шар шувуу, бор шувуу, харцага, тоодог, тагтаа, ногтруу, хулан жороо, өвөөлж зэрэг олон төрлийн шувууд амьдардаг байна. |
| 6 | Тусгай хамгаалалттай газар нутаг | Дорноговь аймгийн хэмжээнд улсын тусгай хамгаалалттай газар нутаг 15, аймгийн тусгай хамгаалалттай газар нутаг 26, сумын тусгай хамгаалалттай газар нутгийн тоо 67 байдаг. Аймгийн нийт газар нутгийн 32.6 хувь нь тусгай хамгаалалттай газар нутаг эзэлнэ.<br>Замын-Үүд сум: Аймгийн Засаг даргын 2011 оны А/638 тоот захирамжаар аймгийн зэрэглэлтэй хот болгон, хотын захирагчийн албыг байгуулсан.Замын-Үүд сум нь 48600 га нутаг дэвсгэртэй, үүний 70 хувийг улсын тусгай хэрэгцээний газар буюу хилийн зурвас газар, төмөр замын зурвас газар эзэлдэг<br>Эрдэнэ сум: Тус сумын нутагт орших Хөх овоо нэртэй газрыг Байгаль, түүхийн дурсгалт газрын зориулалтаар орон нутгийн ТХГН-т 2018 оны 12-р сарын 13-ны өдөр авсан байна. Нийт талбайн хэмжээ нь 9193.54 га юм |
| 7 | Түүх соёлын өв | Дорноговь аймгийн Замын-Үүд, Эрдэнэ сумдын нутагт орших “Хөх овоо” нэртэй 26.3 га талбайд Палеонтологийн хайгуул судалгааны ажлыг Шинжлэх ухааны академи Палеонтологийн хүрээлэнгээр 2019 онд гүйцэтгүүлсэн. Тус |

| | | |
|---|---|---|
| | | судалгаагаар ямар нэгэн эртний амьтан, ургамлын олдвор илрээгүй байна.<br>Угсаатны зүйн авран хамгаалах судалгааны ажлыг ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнгээр 2020 онд гүйцэтгүүлсэн. Судалгааны явцад ямар нэгэн археологийн дурсгал илэрч олдоогүй байна.<br>Цаашид хайгуул, ашиглалтын үе шатанд палеонтологийн сонирхолтой үнэт ховор олдвор, дурсгал илэрсэн тохиолдолд ажлаа түр зогсоож ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнд хандаж “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн дагуу авран хамгаалах малтлага хийлгэх ажил зохион байгуулах нь зүйтэй гэж үзсэн байна. |

# БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

***Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж***

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан магадлан жагсаах, давхцуулан зураглах, загварчлалын арга, харьцуулсан судалгааны арга БОНХЯ-аас /хуучин нэрээр/ гаргасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар /2014/, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц зэргийг ашиглан хийж гүйцэтгэлээ.

## 1.10 ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, ЭРЧИМ

*Хүснэгт 6. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл*

| Байгаль орчны үзүүлэлт | ***Хэлбэр*** | | | ***Хугацаа*** | | ***Хэлбэр*** | | ***Эрчим*** | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Шууд | Шууд бус | Өөрөө зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Бага зэрэг | Дунд зэрэг | Хүчтэй |
| **1. Экосистемийн өөрчлөлт** | | | | | | | | | | |
| Геологийн тогтцын өөрчлөлт | x | | | | x | x | | | | x |
| Ландшафтын төрх байдал өөрчлөгдөх | x | | | | x | x | | | | x |
| Бичил уур амьсгалын өөрчлөлт | | | | | | | | | | |
| **2. Байгалийн нөөц ашиглалт** | | | | | | | | | | |
| Ойн баялаг, түүний дагалт баялаг ашиглах эсэх | | | | | | | | | | |
| Сэргээгдэх эрчим хүч ашиглах эсэх (нар, салхи, усны) | | | | | | | | | | |
| Ашигт малтмал ашиглах | x | | | | x | x | | | | x |
| **3. Байгаль орчны төлөв байдлын чанарын өөрчлөлт** | | | | | | | | | | |
| Гадаргын усны нөөцийн хомсдол үүсэх эсэх | | | | | | | | | | |
| Газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх эсэх | | | | | | | | | | |
| Цэнгэг усны нөөцийг ашиглах эсэх | x | | x | | x | | x | x | | |
| Газрын доорх усанд бохирдол үүсэх эсэх | | x | | x | | x | | x | | |
| Хөрсөн бүрхэвч эвдрэх эсэх | | x | | | x | x | | | x | |
| Хөрс бохирдуулах эсэх | | x | | x | | x | | x | | |
| Хөрс доройтох, цөлжих эсэх | | x | | | x | x | | x | | |
| Ургамлын нөмрөг өртөх | | x | | | x | x | | x | | |
| Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх эсэх | | | | | | | | | | |
| Зэрлэг амьтдын амьдрах орчныг доройтуулах эсэх | | x | x | | x | | x | x | | |
| Ховор, нэн ховор амьтан өртөх эсэх | | | | | | | | | | |
| Бохирдуулагч бодис агаар мандалд ялгаруулах эсэх | | x | | x | | x | | x | | |
| Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх эсэх | | x | | | x | x | | | x | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор** | | | | | | | | | | |
| Байгалийн унаган төрх өөрчлөгдөх | | х | | | х | х | | х | | |
| Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх | | | | | | | | | | |
| **5. Эдийн засаг, нийгмийн асуудал** | | | | | | | | | | |
| Ажлын байр шинээр бий болох | + | | | | + | + | | | + | |
| Өрхийн орлого нэмэгдэх | | + | | | + | + | | | + | |
| Амьжиргааны түвшин дээшлэх | | + | | | + | + | | | + | |
| Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх | | + | | | + | + | | | + | |
| Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох | | + | | | + | + | | | + | |
| **6. Бусад нөлөөлөл** | | | | | | | | | | |
| Аюулт үзэгдэл (хүчтэй шороон шуурга, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах) | | х | х | | х | | х | х | | |
| Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлөлтэй эсэх | | х | | х | | | | х | | |
| Төслийн бүх үе шатанд хүний Эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх | | х | | х | | | х | х | | |
| Сөрөг нөлөөлөл | 4 | 12 | 3 | 5 | 11 | 11 | 4 | 11 | 2 | 3 |
| Нөлөөлөлгүй | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 |
| Эерэг нөлөөлөл | 1 | 4 | 0 | 0 | 5 | 5 | 0 | 0 | 5 | 0 |

“Гантулга трейд” ХХК-ийн Дорноговь аймгийн Замын-Үүд, Эрдэнэ сумдын нутагт орших 2021/001А тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөх овоо” нэртэй дайргын ордыг ил аргаар ашиглах төслийн ашиглалтын явцад байгаль орчны төлөв байдал болон нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг *Магадлан жагсаах* аргаар гаргахад: Уурхайн ашиглалтын явцад үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд шууд болон шууд бус замаар, ихэнх нь урт хугацаатай, эрчмийн хувьд харилцан адилгүй нөлөөллүүд байна. Тодруулбал:

***Шууд нөлөөлөл:*** Төслийн явцад байгалийн нөөц болох ашигт малтмал ашиглах, геологийн тогтцын өөрчлөлт, ландшафтын төрх байдал, байгалийн унаган төрх өөрчлөгдөх, хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэх, ургамлын нөмрөг өөрчлөгдөх, цэнгэг усны нөөц ашиглах, төслийн явцад ашиглагдах техник, тоног төхөөрөмжөөс бохирдуулагч бодис агаар мандалд ялгаруулах, дуу чимээ үүсэх зэргээр шууд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Мөн өрөмдлөг, тэсэлгээний ажилтай холбоотой доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх нөлөөлөл байж болзошгүй.

Харин нийгэм, эдийн засагт шинээр 32 ажлын байр бий болох шууд эерэг нөлөөлөлтэй байна.

***Шууд бус нөлөөлөл:*** Төслийн явцад газрын доорх ус болон хөрс бохирдох, хөрс доройтох, цөлжих, байгалийн зэрлэг амьтдын амьдрах орчныг доройтох зэргээр шууд бус, дам нөлөөлөл үзүүлж болзошгүй. Мөн аюулт үзэгдэл тохиолдох, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдал алдагдсанаас хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэж болзошгүй.

Нийгэм, эдийн засаг ажлын байр шинээр бий болсноор өрхийн орлого нэмэгдэх, амьжиргааны түвшин дээшлэх, ядуурлыг бууруулахад дэмжлэг болохоос гадна эдийн засгийн эргэлтээр татвар хураамжаар дамжин орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх, дэд бүтэц сайжрах олон талын ач холбогдолтой. ТЭЗҮ-д тусгагдсанаар улс болон орон нутгийн төсөвт жилд дунджаар 478.0 сая төгрөг, уурхайн ашиглалтын нийт хугацаанд 4.56 тэрбум төгрөгийн татвар төлбөрийг төвлөрүүлнэ. Хугацааны хувьд ихэнх нөлөөлөл нь төслийн цар хүрээнээс хамаарч урт хугацаанд багтаж байгаа боловч нөлөөллийн үргэлжлэх хугацаа богино нөлөөллүүд байна. Үүнд: газрын доорх ус, хөрс бохирдох, агаар мандалд бохирдуулагч хий ялгарах, хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэх зэрэг. Эдгээр болзошгүй

нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах бүрэн боломжтой тул хугацааны хувьд богино нөлөөлөл гэж үзлээ.
Нөлөөллийн эрчмийн хувьд харилцан адилгүй бөгөөд бага нөлөөлөлд ихэнхдээ хугацааны хувьд богино нөлөөлөлд хамрагдаж байна. Тухайлбал: газрын доорх ус болон хөрс бохирдох, хөрс доройтох, цөлжих, ургамлын нөмрөг өртөх, зэрлэг амьтдын амьдрах орчныг доройтох, бохирдуулагч бодис агаар мандалд ялгарах. Мөн уурхайн ашиглалтын явцад технологийн ус шаардахгүй бөгөөд зөвхөн ажилчдын унд-ахуй, тоосжилт дарах, өрөмдлөг, техникийн зорилгоор ус ашиглана. Иймээс цэвэр усны нөөцөд нөлөөлөх нөлөөлөл бага байна, дунд нөлөөлөлд хөрсөн бүрхэвч эвдрэх, дуу чимээний бохирдлыг орууллаа. Харин хүчтэй нөлөөлөлд геологийн тогтцын өөрчлөлт, ландшафтын төрх байдал өөрчлөгдөх, ашигт малтмал ашиглах зэрэг уул уурхайн үйл ажиллагаанд хамгийн ихээр өртөж, төрх байдал нь өөрчлөгдөж доройтох хэсгүүдийг хамааруулж авч үзлээ.

*Хүснэгт 7. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах*

| Байгаль орчны асуудал | Нөлөөлөл байхгүй | Гол үр дагавар | | |
|---|---|---|---|---|
| | | Бага | Дунд | Их |
| **1. Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд** | | | | |
| Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх | | | | x |
| Төсөл хэрэгжих талбай, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх | x | | | |
| Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, тусгай хамгаалалттай газар) | x | | | |
| Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа эсэх | | x | | |
| Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх эсэх | x | | | |
| Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх эсэх | x | | | |
| Булаг, шандын усны горимд өөрчлөлт орох ба хатах ширгэх үгүй болох аюултай эсэх | x | | | |
| **2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбогдох шалгуурууд** | | | | |
| Төслийн үйл ажиллагаа нь тухайн орон нутагт нийцэх эсэх | | | | x |
| Дэд бүтцийн хөгжил | | | x | |
| Хог хаягдлын менежментийн арга хэмжээ | | | | x |
| Байгальд ээлтэй материал, тоног төхөөрөмж ашиглах эсэх | | x | | |
| **3.Аюулгүй ажиллагаа** | | | | |
| Ашиглалтын шатны бүтээн байгуулалт, санхүүгийн боломжийн талаарх асуудал | | | | x |
| Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалт | | | | x |
| **4. Төсөл хэрэгжүүлэх үеийн холбогдох шалгуурууд** | | | | |
| Төслийн үйл ажиллагааны талаарх төлөвлөгөө хэр зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх | | x | | |
| Төслийн үйл ажиллагааны явцад анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гарах эсэх | | | x | |
| Байгаль хамгаалах төлөвлөгөө | | | | x |
| Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр | | | | x |
| **5. Төслийг ерөнхийнд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)** | | | | |
| Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн акт, стандартын шаардлагыг хангах эсэх | | | | x |
| Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх | | | x | |
| **Нөлөөллийн үнэлгээний тоон утгын нийлбэр хэмжээ** | **5** | **3** | **3** | **8** |
| **Нөлөөллийн үнэлгээний тоон утгын хувь хэмжээ, %** | **26%** | **16%** | **16%** | **42%** |

Уг төсөл нь Дорноговь аймгийн Замын-Үүд, Эрдэнэ сумдын нутаг дэвсгэр, байгалийн бүс бүслүүрээр хээрийн бүсэд хэрэгжинэ.
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий.
Төслийн талбайд гадаргын усан сан байхгүй. Хуулиар хамгаалагдсан газар нутаг (урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, тусгай хамгаалалттай газар)–ийн хилийн бүстэй давхцахгүй. Хамгийн ойр байрлах айл тусгай зөвшөөрлийн талбайн гадна хилээс 1,5 км зайд оршдог тул одоогийн байдлаар нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авагдахгүй болно.
Тусгай зөвшөөрлийн талбайгаас хойш 255 м зайд Хөх овоо нэртэй орон нутгийн ТХГН-ийн хил байрлана. Тус газрыг 2018 оны 12-р сарын 13-ны өдөр Байгаль, түүхийн дурсгалт газрын зориулалтаар орон нутгийн ТХГН-т авсан байна.

## 1.11 ТӨСЛИЙН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ

Төсөл хэрэгжих орчны цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүдийг Дорноговь аймгийн Сайншанд сумын цаг уурын Сайншанд станцын мэдээ, Эрдэнэ сумын цаг уурын Улаан-Уул станцын мэдээ, цаг уур орчны шинжилгээний газрын олон жилийн дүн мэдээнд тулгуурлан тодорхойллоо.

***Газрын гадарга***

"Гантулга трейд" ХХК-ийн "Хөх овоо" нэртэй дайргын ордыг ил аргаар ашиглах төслийн хөрс хуулалт, овоолго, олборлолт, бутлан ангилах цехийн үйл ажиллагааны улмаас агаарын чанар, газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ус, ургамлын нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

***Агаарын температур***

Төсөл хэрэгжих орчин нь уур амьсгалын мужлалаар эх газрын эрс тэс уур амьсгалтай, нэн хуурай, өвөл нь жиндүү хүйтэн, салхины нөлөө их байдаг нь энэ нутгийн онцлог юм. Уур амьсгалын хувьд гандуу дулаан зунтай хүйтэн өвөлтэй.
Хамгийн их хүйтрэлт 1-р сард -25$^0$ хүрэх ба хамгийн халуун 7-р сард +35-40$^0$ хүрнэ. Жилийн дундаж температур 5,5$^0$, Агаарын харьцангуй чийгшил дунджаар 40-50% байна. Ус чийг багатай тул манан будан ажиглагдахгүй. Хур тунадасны хэмжээ дутмаг. Зуны улиралд түр зуурын бороо ордог. Үргэлжилсэн олон хоногийн бороо ордоггүй.

***Хур тунадас***

Орд орчмын нутгаар 2023 оны жилд дунджаар хамгийн багадаа 0.2 мм хамгийн ихдээ 15.9 мм хур тунадас буюу оны нийлбэр дундаж нь 5.5 мм хур тунадас орсон байна. Хур тунадастай өдрийн тоо 47 байна.
Дорноговь аймгийн нийт нутгаар хур тунадасны жилийн нийлбэрийн олон жилийн өөрчлөлтийг авч үзээд зарим нутгаар хур тунадасны хэмжээ өссөн байхад зарим нутгаар өөрчлөлтгүй буюу буурсан байна.
Хур тунадасны өөрчлөлтөөс харахад зарим нутгаар жилийн нийлбэр тунадас өссөн байгаа нь температурын дулааралтын улмаас аадар борооны тоо хэмжээ, эрчимжил ихсэж байгаатай холбон үзэж болох юм.

***Салхи***

2023 онд жилийн хамгийн бага салхины хурд 13 м/сек, хамгийн их салхины хурд нь 27 м/сек хүрч байсан байна. Мөн хүчтэй салхитай өдрийн дундаж тоо 19, цасан шуургатай өдрийн тоо 8, шороон шуургатай өдрийн тоо дээрх онуудад хамгийн 49 байгаа нь манай орны бусад нутагтай харьцангуй салхи шуурга ихтэй байгааг харуулж байна. Салхины

зонхилох зүг нь баруун, баруун хойноос бүх тохиолдлын 51%-ийг эзэлж ялангуяа 3-5 дугаар сард салхины хурд ихэсдэг.

***Уур амьсгалд үзүүлэх сөрөг нөлөөлөл***

Төслийг хэрэгжүүлэх явцад уур амьсгалын нөлөөллийг тооцохдоо хоёр талтай үнэлгээ хийсэн. Төслөөс уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх болон цаг агаарын байдал эргээд төслийн үйл ажиллагаанд үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг авч үзлээ. Үүнд:

- Дайрга олборлолтын үйл ажиллагаанд ажиллаж байгаа машин техникийн түлшний дутуу шаталтаас агаар мандалд маш бага хэмжээний хүлэмжийн хийн ялгарал үүсгэнэ.
- Байгаль, цаг агаарын аюултай үзэгдэл нь тоног төхөөрөмж, эд хөрөнгөд эвдрэл гэмтэл учруулж болзошгүй.

***Агаарын чанар***

Уурхай орчмын нутаг дэвсгэрийн хөрс эвдэгдэн тоосрох, хүнд даацын автомашины хөдөлгөөн, автомашин механизмын яндангаас гарах хорт хийн хаягдал нь агаар дахь бохирдуулах бодисын агууламжийг ихэсгэнэ. Нөлөөллийн эрчмийн хувьд технологийн үе шатуудад дунд зэрэг сөрөг нөлөөлөлтэй байна.

Уурхайг ашиглах үеийн ажлуудаас үүсэх тоосжилт, уг ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизм, тээврийн хэрэгслээс гарах утаа зэрэг эх үүсвэрүүдээс тоосжилт, агаарын бохирдол үүснэ.

***Усан орчин***

Энэ талбайд байнгын урсгалтай гол, горхи байхгүй, зөвхөн ул чулуулгийн ан цавын болон хөндий хотгор дахь сэвсгэр хурдасны ус тохиолдоно. Түүнчлэн төсөл хэрэгжүүлэх явцад технологийн ус ашиглахгүй бөгөөд зөвхөн унд ахуйн болон тоосжилтыг багасгах зорилгоор ус ашиглах юм. Энэхүү усны хэрэгцээг төслийн талбай орчимд байх гүний худгаас зөөврөөр хэрэглэхээр төлөвлөсөн. Төслийн хүрээн дэх ахуйн хэрэгцээнд ашиглах усыг зөөврөөр авч ашиглах тул усны нөөцөд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй болно.

Говийн нутаг дэвсгэрт усны нөхөн сэргээгдэх нөөц маш бага байдаг ба түүнээс ашиглах боломжит нөөц бүр ч хязгаарлагдмал, орон зай, цаг хугацааны хувьд жигд бус тархацтай байна. Судалгааны талбай орчимд хийсэн гидрогеологийн эрэл хайгуул хийсэн талбай, газрын доорх усны орд нь тусгай зөвшөөрлийн талбайн зүүн талд 12-13 км зайд хийгдсэн байна.

Тухайн төслийн ашигт малтмалын судлагдсан гүн 14-25 м, ашигт малтмалын дундаж зузаан 18.83 м байна. Ордын өрөмдсөн цооногуудад гүний ус илрээгүй тул ордыг ил уурхайн аргаар ашиглахад гүний устай холбоотой хүндрэл үүсэхгүй.

Төслийн явцад гадаргын болон газрын доорх усанд нөөцийн хомсдол үүсэхгүй.

***Хөрсөн бүрхэвч***

Төслийн талбайд зүсэлт хийсэн гадарга орчимд уурхайн ашиглалт харьцангуй бага, уурхайн нэгжүүдийн ашиглалт их явагдсан, хөндийн хэсэгт уурхайн суурин талбайн зарим хэсэгт байгуулсан, хогийн болон авто засварын газар зэрэг нэгжүүд нь байрласан.

Уурхайн талбайн хөрсөн бүрхэвч нь эмзэг, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, үржил шим багатай хөрс зонхилох тул элэгдэл, эвдрэлд орох нь хялбар.

Ажилчдын амрах байр, цайны газар, засварын цех, сэлбэг материалын агуулах, ШТС, тэсрэх материалын түр агуулах барьж байгуулах, уурхайн зам үүсгэх, хог хаягдлын түр цэг байгуулах, өрөмдлөг, тэсэлгээ, олборлолт, бутлан ангилан цехийн талбай зэргээс хүн, техникийн хөдөлгөөнөөр талхлагдаж эвдрэлд орно.

***Ургамлан нөмрөг***

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн ойр орчимд нийт 12 овгийн 20 гаруй төрөлд хамаарагдах 31 зүйл ургамал бүртгэгдлээ. Овгуудын дотроос үетэн- 6 зүйл, нийлмэл цэцэгтэн- 4 зүйл, луультан 6 зүйлтэйгээр зонхилон, бусад овгийн ургамал 1-3 зүйлтэй тохиолдоно. Түүнчлэн зүйлүүдийн дотроос сөөг 4 зүйл, заримдаг сөөгөнцөр 2 зүйл, нэг наст ургамал 9, олон наст ургамал 14 зүйл ургаж байна. Ургамал нөмрөгт дундаас бага сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Иймээс байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг цаг тухай бүр нь стандарт, аргачлалын дагуу хэрэгжүүлэх, ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төслийн хэмжээнд тогтмол хэрэгжүүлснээр ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байлгах бүрэн боломжтой байна.

***Амьтны аймагт нөлөөлөх байдал***

Эрдэнэ сумын нутагт орших Хөх овоо нэртэй газрыг Байгаль, түүхийн дурсгалт газрын зориулалтаар орон нутгийн ТХГН-т 2018 оны 12-р сарын 13-ны өдөр авсан байна.

1. Дэлхий дээр болон Монгол улсад ховор, ховордсон ан амьтдын идээшил суурин, нүүдлийн шувууд, үржлийн бүс нутаг учраас уул уурхай, хориотой ан агнуур, аялал жуулчлал нь ан амьтдын бүс нутгийг хомсдуулах, тоо толгойг бууруулах,
2. Төслийн үйл ажиллагааны улмаас тухайн орчны агаар, хөрс бохирдохын хирээр ургамлын нөмрөгт тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарах бөгөөд үүнтэй уялдан амьтны аймгийн амьдрах орчин доройтож, идэш тэжээл нь хомсдож, тархац, газар нутгийн хэмжээ хумигдана.
3. Зарим шавжийн амьдрах орчныг устгах, хүнд машин техникийн ажиллагаанаас гарах дуу чимээнээс амьтан, шувууд дайжих;
4. Уул уурхайн ачилт, тээвэрлэлт нь нутгийн замаар явж хөрсийг эвдлэх, дуу чимээ нь хөхтөн амьтдын нүүдлийн замыг хааж нутаг дэвсгэрийн хувьд хязгаарлал үүсгэнэ,
5. Үйлдвэрийн ойр орчмын бүтээн байгуулалтын цахилгаан шугам сүлжээ, өндөр хүчдэлийн шугам нь шувуудын аюулгүй байдалд нөлөөлнө.
6. Шөнийн цагаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулна. Дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьдад идэш тэжээлээ барих зэрэгт нөлөөлнө.
7. Хориотой ан агнуур
8. Булаг шанд багасах, ширгэх
9. Айлуудын 5-н хошуу малын усны нөөц, бэлчээрийн талхагдал.

Төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан дуу чимээ, тоос гарах, усны нөөц багасах, бэлчээрийн доройтол болох зэрэг сөрөг үзүүлэлт гарснаар зэрлэг ан амьтад мөн сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

***Нийгэмд нөлөөлөх байдал***

Орон нутгийн ажил эрхлэлт, мэргэжил боловсрол, орон нутгийн хөгжил нэмэгдэж, ард иргэдийн аж амьдрал сайжирна. Гэхдээ орон нутгийн иргэдийн мэргэжил, боловсролын түвшин төслийн шаардлагад хүрэхгүй, ажилд орж чадаагүйн улмаас төслөөс ахиц өөрчлөлт хүлээж байсан иргэд сэтгэл дундуур үлдэх, гомдол, эсэргүүцэл гарч болзошгүй.

Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл, техникийн дуу шуугиан, тээврийн хэрэгслийн улмаас үүсэх тоосжилт зэрэг нь төслийн талбай, түүний ойр суурьших айл өрхийн амгалан тайван байдал алдагдах зэргээр амьдралын хэвийн байдалд сөрөг нөлөө үзүүлнэ.

Төсөл хэрэгжсэнээр хүний хөл олширч зөрчил, Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс үйлдвэрлэлийн осол үүсэх нөхцөл үүсэж болзошгүй.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгааны явцад хөрсөнд цацрагийн үүсгүүр илрээгүй ч дайрга олборлолтын үйл явцаас цацрагийн үүсгүүр илрэх, барилга байгууламжид ашиглах явцад дам нөлөөгөөр цацрагийн нөлөөлөл үүсгэж болзошгүй.

***Нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл***

Төсөл хэрэгжсэнээр түр ажлын байрууд үүсэж, орон нутгийн ажил эрхлэлтэд тодорхой хэмжээгээр эерэг нөлөө үзүүлнэ.

Орон нутгийн ажил эрхлэлт, мэргэжил боловсрол, дэд бүтцийн хөгжил нэмэгдэж, ард иргэдийн аж амьдрал сайжирна.

Төсөл хэрэгжсэнээр татвар болон төлбөр төлөлтөөс улс, орон нутгийн төсөвт эерэг нөлөөтэй.

Төслийн хүрээнд ашиглагдах хоол хүнс, бараа бүтээгдэхүүнийг орон нутгаас бэлтгэх бололцоотой хүнс, тэжээлийн хангамжийг авч, ард иргэд болон малчдын эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

***Түүх соёлын дурсгалт зүйлс***

Соёлын өвийн бүртгэлд бүртгэгдсэн газруудын байршлыг тогтоож өгснөөр төслийн үйл ажиллагааны хүрээнд соёлын өвийг хамгаалах нөхцөл бүрдэх юм.

Түүх соёлын дурсгалт зүйлс тэмдэглэгдэж байсан газарт хайгуулын үйл ажиллагаа явуулахгүй байх, энэхүү төсөл хэрэгжүүлэх явцад мэдэгдээгүй түүх дурсгалын зүйлс, булш, бунхан, хиргисүүр, археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд түүх соёлын үнэт өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагаагаа зогсоож хамгаалалт гарган зохих хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, улмаар тухайн газар нутгийг бүрэн хамгаалалтад авах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай.

# БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 1.12 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)ний зорилго нь төслийн бүхий л үе шатанд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар төсөл хэрэгжүүлэгч энэхүү төлөвлөгөөг дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

БОМТ-ний үндсэн зорилгыг хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхын хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах зорилтыг хангана. Үүнд:

- ✓ БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг нөхөн сэргээлтэд тавих шаардлагын хэмжээнд хүргэх;
- ✓ БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
- ✓ БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах нөхцөлийг бүрдүүлнэ.

БОМТ нь төслийн үйл ажиллагааны цар хүрээнд байгаль орчин, нийгмийн хамгааллын дараах асуудлыг хамарч, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө. Үүнд:

- ✓ Төслийн хүрээнд бий болох сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, холбогдох зардлыг тооцох;
- ✓ Нөхөн сэргээх, нөхөн хамгаалах ажлыг төлөвлөж, зардлыг тооцох;
- ✓ Түр нүүлгэн шилжүүлэлт хийх ажлын дэс дараалал, зохион байгуулалт, холбогдох зардлыг тооцох;
- ✓ Осол, эрсдэл, аюултай нөхцөл байдлын үед хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчныг хамгаалах бодлогыг тодорхойлох;
- ✓ Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг зааж, холбогдох зардлыг тооцох;
- ✓ Нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийг олон нийтэд таниулах зэрэг асуудлыг тусгана.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлээгүйгээс байгаль орчинд учирсан хохирлыг арилгах,  нөхөн төлбөрийг төлөх үүргийг төсөл хэрэгжүүлэгч хүлээнэ.

## 1.13 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

*Хүснэгт 8. Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн үнэлгээ, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Баримтлах хууль, журам, стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | | Газрын хэвлий | | | | | | | |
| 1.1 | Уурхайн ашиглалтын 10 жилийн хугацаанд нийт 9.7 га талбай эвдрэл, элэгдэлд өртөх, | Шимт хөрс хуулалтын ажлыг чанартай гүйцэтгэж,уурхайн өрөмдлөг, тэсэлгээг нарийвчлан тодорхойлсон төлөвлөгөөний дагуу хийж, овоолгуудын байршлыг оновчтойгоор сонгох | Уурхайн лицензийн талбай | - | - | - | Үйл ажиллагааны зардалд | 2025 он | MNS 5915:2008 Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал стандартыг |
| 1.2 | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, тэсэлгээний улмаас үүссэн тоосжилтоор газрын гадарга ургамлын нөмрөг бохирдох, | Тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг мөрдүүлэн ажиллаж, аль болох тоосжилтыг бага байлгах хэрэгтэй. Салхи шуурга ихтэй үед тоос дарах нэмэлт арга хэмжээ авах, байгууламж хооронд нэг тогтсон замаар зорчиж байх, | Уурхайн лицензийн талбай | - | 200.0₮ | 1 | 200.0₮ | 2025 он | |
| 1.3 | Төслийн үйл ажиллагаанаас гарсан хатуу хог хаягдлаар газрын гадаргыг бохирдуулах, салхи, усаар зөөгдөн ойр орчмын газрын гадаргыг бохирдуулах, | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, тусдаа байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах | Уурхайн лицензийн талбай | - | - | - | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд | 2025 онд | |
| 1.4 | Шингэн хаягдал хөрсөнд ил задгай хаягдсанаас орчны хөрсийг, улмаар гүний ус, хөрс, | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, тусдаа байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах | Уурхайн лицензийн талбай | - | - | - | Хог хаягдлын менежментийн | 2025 онд | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ургамлыг бохирдуулах, | | | | | | төлөвлөгө өнд | | |
| 1.5 | Засварын газар, техник тоног төхөөрөмжөөс ШТМ алдагдаж, газрын гадарга хэвлийг бохирдуулах; | Засварын газрыг стандартын дагуу байгуулах, ил уурхайн тэсэлгээний үеийн чичиргээг тооцоолон байгуулах, материалын агуулахыг байгалийн гэнэтийн аюул, ослуудад тэсвэртэй байхаар төлөвлөх | Засварын газар орчим | - | - | - | Үйл ажиллагаа ны зардалд | 2025 онд | |
| 1 | Агаарын чанар | | | | | | | | |
| | Ил уурхай, овоолго, зам талбай үүсэх ба эдгээр эвдэгдсэн талбайгаас тоос агаарт дэгдэх | Ногоон байгууламж байгуулах, олон шинэ зам үүсгэхгүй байх, тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлаж, тогтмол хяналт тавих, тоос дарагч бүтээгдэхүүнийг устай хольж шүрших, | Ил уурхай, овоолго | - | - | - | Үйл ажиллагаа ны зардалд | 2025 онд | Агаарын тухай хууль,<br><br>MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага<br><br>Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 MNS 5002:2000 Хөдөлмөрийн |
| 1.1 | Тэсэлгээний үеийн болон үйл ажиллагааны үеийн дуу чимээ | Уурхайн тэсэлгээг дүрэм, журмын дагуу хийх | Ил уурхай | - | - | - | Үйл ажиллагаа ны зардалд | 2025 онд | |
| 1.2 | Ачаа тээвэрлэлтийн үед хүнд даацын машин механизмын хөдөлгөөний улмаас үүсэх тоосжилт | Олон шинэ зам үүсгэхгүй байх, тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлаж, тогтмол хяналт тавих, тоос дарагч бүтээгдэхүүнийг устай хольж шүрших, | Уурхайн лицензийн талбай | - | - | - | Үйл ажиллагаа ны зардалд | 2025 онд | |
| | Бутлуурын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт | | Бутлуурын цех | - | - | - | Үйл ажиллагаа ны зардалд | 2025 онд | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/ | Машин механизмуудаас гарах хийнд тогтмол шинжилгээ хийж, стандарын шаардлага хангасан тээврийн хэрэгслүүдийг уурхайд ашиглах, стандартын шаардлага давсан машин механизмуудад шүүлтүүр суурилуулах, ашиглалтын хугацаа дууссан тээврийн хэрэгслийг ашиглалтаас гаргах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх | Уурхайн лицензийн талбай | - | - | - | Үйл ажиллагаа ны зардалд | 2025 онд | аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага |
| | Байгалийн хүчин зүйл /шороон шуурга/ | Төслийн барилга байгууламжийн зураг төсөлд тусгагдсан явган зам, тээврийн хэрэгслийн зогсоол зэрэг газруудыг технологийн дагуу хучилт хийж байгуулах | Уурхайн лицензийн талбай | - | - | - | Үйл ажиллагаа ны зардалд | 2025 онд | |
| 2 | Гадаргын ба газрын доорх усны нөөц | | | | | | | | |
| 2.1 | Гүний усны нөөцөд нөлөөлөх | Унд ахуйн усны хэрэгцээнд хяналт тавих, усны хэрэглээг багасгах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх | Ажилчдын байр | - | - | - | Үйл ажиллагаа ны зардалд | 2025 онд | Усны тухай хууль, 2012<br><br>Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012<br><br>MNS 4943:2015 (Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага) |
| 2.2 | Уурхайн талбайд байрлах засварын газрын үйл ажиллагаанаас гарсан шатах тослох материалын хаягдал санамсар болгоомжгүй байдлаас алдагдаж асгарснаас хөрс бохирдож улмаар газрын доорх ус бохирдож болзошгүй. | Засварын газрыг стандартын дагуу байгуулах, ил уурхайн тэсэлгээний үеийн чичиргээг тооцоолон байгуулах, материалын агуулахыг байгалийн гэнэтийн аюул, ослуудад тэсвэртэй байхаар төлөвлөх | Засварын газар | - | - | - | Үйл ажиллагаа ны зардалд | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3 | Хатуу, шингэн хог хаягдал санаатай болон санамсар болгоомжгүй байдлаас хөрсөнд ил задгай хаягдаж болзошгүй бөгөөд улмаар хөрсөөр дамжин газрын доорх усыг бохирдуулах эх үүсвэр болж болзошгүй. | Бохир ус хөрсөнд алдагдахаас сэргийлэх, бохирдсон тохиолдолд гарах эрсдэлийг тооцон зохих урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, ХАБ, байгаль орчны чиглэлийн сургалтуудаа энэ чиглэлийн мэдээллийг оруулах, | Хог хаягдлын цэг | - | - | - | Үйл ажиллагааны зардалд | | |
| 2.4 | Хог хаягдлын түр цэг бетон суурьгүй тохиолдолд хөрсний бохирдол үүсгэж, улмаар газрын доорх усны чанар найрлагад өөрчлөлт оруулж болзошгүй | Хатуу хог хаягдлын цэгийг битүүмжилж хатуу хучилттай болгох | Хог хаягдлын цэг | - | - | - | Үйл ажиллагааны зардалд | 2025 онд | |
| 3 | Хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөг | | | | | | | | |
| 3.1 | Төслийн үйл ажиллагаанд өртөх 7.4 га талбайн ургамлан нөмрөг,хөрсөн бүрхэвч ил уурхай, барилга байгууламж байгуулахад урт хугацаанд устах, дарагдах, доройтох нөлөөлөлд өртөх, | Шимт хөрсийг 0.3-0.4 метрийн зузаантайгаар хуулж, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн ажилд ашиглах зорилгоор шимт хөрсний овоолгуудад хадгалах | Уурхайн лицензийн талбай | - | - | | Үйл ажиллагааны зардалд | 2025 онд | Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008 |
| 3.2 | Хүдэр бутлах, дамжуулах; хөрс ачих, буулгах; тэсэлгээ, тээврийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэж, | Ургамлын мониторинг судалгаа хийлгэх | Уурхайн лицензийн талбай | - | 5000.0₮ | 1 | 5000.0₮ | 2025 онд | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | орчны ургамлан нөмрөгт нөлөөлөх | | | | | | | | |
| 3.3 | Ахуйн болон үйлдвэрийн гаралтай шингэн, хатуу хог хаягдлууд үүсэж түүнийг цуглуулах, устгах, халдваргүйжүүлэх арга хэмжээ аваагүйн улмаас ургамлан нөмрөг, хөрсний үржил шим, физик, химийн үзүүлэлт, гадаргын болон хөрсний ус, агаарын чанар, хүн, амьтны эрүүл мэнд зэрэг үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлж болзошгүй | Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж, хураан хуримтлуулах зориулалтын цэг төлөвлөн байршуулах, хашаа, хязгаараас гадна элдэв, хог хаягдал хаяхгүй, газрын төрх, төслийн талбайн хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх | Уурхайн лицензийн талбай | - | 200.0₮ | 1 | 200.0₮ | 2025 онд | |
| 3.4 | Төслийн үйл ажиллагаанаас барилга байгууламжийн дор эрүүл хөрс дарагдах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хөрс талхлагдах сөрөг нөлөөлөл гарч болзошгүй | Олон шинэ зам үүсгэхгүй байх, тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлаж, тогтмол хяналт тавих, | Уурхайн лицензийн талбай | - | 400.0₮ | 1 | 400.0₮ | 2025 онд | |
| 3.5 | Төслийн хүрээнд үржил шимт хөрс хуулах бөгөөд уг хөрсийг буруу хадгалдсанаас үүдэн үржил шимт хөрс хур бороонгы усаар урсах, алдагдан, | Уурхайн барилга байгууламжуудыг барихаас өмнө эвдрэх талбайн үржил шимт хөрсийг MNS 5916:2008 (Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт) стандартын дагуу | Шимт хөрсний овоолго | - | - | - | Үйл ажиллагаа ны зардалд | 2025 онд | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тоосжилт үүсэх нэг нөхцөл болж болзошгүй | хуулан шимт хөрсний овоолгод байршуулах | | | | | | | |
| 3.6 | Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор уурхайн барилга байгууламжийн хоорондуур зорчих олон салаа зам гарч болзошгүй | Төслийн талбай орчмын зам харилцааг сайжруулах, тээврийн хэрэгслийг нэг чиглэлийн замаар зорчуулах | Уурхайн барилга байгууламж | - | - | - | Үйл ажиллагаа ны зардалд | 2025 онд | |
| 3.7 | Тээврийн хэрэгслийн хэвийн ажиллагаанд доголдол гарч, шатах тослох материалын шүүрэлт үүсэж хөрсний үржил шим, физик, химийн шинж чанарыг алдагдуулж болзошгүй | Машин механизмуудаас гарах хийнд тогтмол шинжилгээ хийж, стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслүүдийг уурхайд ашиглах, стандартын шаардлага давсан машин механизмуудад шүүлтүүр суурилуулах, ашиглалтын хугацаа дууссан тээврийн хэрэгслийг ашиглалтаас гаргах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх | Уурхайн лицензийн талбай | - | - | - | Үйл ажиллагаа ны зардалд | 2025 онд | |
| 3.8 | Хог хаягдлын цэгийн талбайн ойролцоох газрын гадаргыг бетондоогүйгээс түүгээр дамжин хөрсөн бүрхэвчинд бохирдол үүсэх | Хатуу хог хаягдлаар дамжин хөрсөн бүрхэвч бохирдохоос сэргийлэн хог хаягдлын цэгийн талбайн суурийг бетондох | Хог хаягдлын цэг | - | - | - | Хог хаягдлын менежмен тийн төлөвлөгө өнд | 2025 онд | |
| 4 | Амьтны аймаг | | | | | | | | |
| 4.1 | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, дуу чимээ, тэсэлгээний улмаас байршиж буй | Нутгийн иргэдтэй хамтран амьтдын судалгаа, тархацын талаар бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх | Уурхайн лицензийн талбай орчим | - | 250.0₮ | 1 | 250.0₮ | | Амьтны тухай хууль |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2 | газар нутгаасаа үргэх, дайжих | тээвэрлэлтийн үед амьтдын амьдрах орчин, шилжилт хөдөлгөөнд саад учруулахгүй байх | Уурхайн лицензийн талбай орчим | - | - | - | Үйл ажиллагааны зардал | | |
| 4.3 | | Амьтны мониторингийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх | Уурхайн лицензийн талбай орчим | - | 2.000.0₮ | 1 | 2.000.0 | | |
| 4.4 | Үйл ажиллагаанаас гарсан хаягдлыг хог хаягдлын цэгт удаан байлгах, улмаар муудсан хаягдлыг суурин амьтад идэх, хордох | Орон нутгийн ТҮК-тэй хог хаягдал зайлуулах гэрээ байгуулж, тогтмол хог хаягдлыг зайлуулж байх | Хог хаягдлын цэг | - | - | - | Үйл ажиллагааны зардалд | | |
| 4.5 | Ажилчид хууль бус ан агнуурын гэмт хэрэгт холбогдох, амьтны эд эрхтэн худалдан борлуулах гэмт хэрэгт холбогдох | Нийт ажилчдад амьтны тухай хуулийн сургалт хийх, Ан амьтантай холбоотой гэмт хэргийг мэдээлэх үүргийг таниулах | - | - | - | - | Дотоод нөөцөд тулгуурлан зохион байгуулах | | |
| 5 | Удирдлага зохион байгуулалт | | | | | | | | |
| 5.1 | Байгаль орчныг хамгаалах талаар сургалт, Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах | Төслийн хүрээнд | - | 500.0₮ | - | | 500.0₮ | | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод журам |
| 5.2 | Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах | Төслийн эхэнд | - | - | - | | - | | |
| 5.3 | Эрүүл мэндийн үзлэгт хамруулах, сургалт зохион байгуулах | Уурхайн ажилчид | - | 500.0₮ | - | | 500.0₮ | | |
| 5.4 | Байгалийн гамшиг, гэнэтийн ослоос сэргийлэх арга | Төслийн хүрээнд | - | 500.0₮ | - | | 500.0₮ | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээний төлөвлөгөө боловсруулах, сургалт зохион байгуулах | | | | | | | | |
| 5.5 | Цахилгааны сүлжээний бүрэн бүтэн байдалд мэргэжлийн байгууллагаар үзлэг хийлгэж, дүгнэлт гаргуулж байх | Төслийн хүрээнд | - | 500.0₮ | - | | 500.0₮ | | |
| **5.6** | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа гүйцэтгүүлэх | Төслийн хүрээнд | - | - | - | | Орчны хяналт шинжилгээний дардалд тусгасан | | Газрын тухай хууль |
| | Нийт | **10,050.0₮** | | | | | | | |

## 1.14 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Ашиглалтын талбайд нөхөн сэргээлт хийх талбай үүсэхгүй. Бид уурхайн талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мөн Тэр бум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих зорилгоор ашиглалтын талбай 500 ширхэг мод тарихаар төлөвлөлөө.

*Хүснэгт 9. Нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Нөхөн сэргээлтийн зорилго | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Хэмжих нэгж | Нэгжийн үнэлгээ, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Баримтлах хууль, журам, стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Техникийн нөхөн сэргээлт | Хаягдал хайргыг зам талбай, машин зогсоол тоос хийсэх боломжит талбайд дэвсэх | - | - | - | ҮАЗ | | |
| | Биологийн нөхөн сэргээлт | Уурхайн талбайд ногоон байгууламж үүсгэх мод тарих | 500 Ширхэг | 18.0₮ | - | 9000.0₮ | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Уурхайн хаалт, нөхөн сэргээлт | Жил бүр уурхайн хаалтад зориулж хуримтлуулах мөнгө | | | | УАЗ | | |
| | | | | | | | | |
| | **Нийт** | | | | | **9000.0** | | |

## 1.15 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

*Хүснэгт 10. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Баримтлах хууль, журам, стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Төсөл эхлэхээс өмнөх байдалтай адилтган дүйцүүлэх | Төсөл хэрэгжих буй сум орон нутгаас санал авах | | - | - | 2000.0 | Жил бүр | Байгаль орчны үнэлгээний тухай хууль |
| | | “Тэр бум мод” -ны төслийн хүрээнд | | 1000 ширхэг | - | 6000.0 | Жил бүр | |
| | **Нийт** | | | | | **8000.0** | | |

## 1.16 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

“Гантулга трейд” ХХК-ийн Дорноговь аймгийн Замын-Үүд, Эрдэнэ сумдын нутагт орших 2021/001А тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөх овоо” нэртэй дайргын ордын талбайд одоогоор айл байхгүй учир нүүлгэн шилжүүлэлт хийгдэхгүй болно

## 1.17 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагаа түр хугацаагаар зогсоон, улмаар авран хамгаалах, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулуулах хэрэгтэй.

*Хүснэгт 11. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө*

| № | Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн өртөг | Нийт зардал (сая.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | АМТЗ-ийн талбай орчим болон дотор байх түүх соёлын өвүүд | Олборлолтын үйл ажиллагаанд түүх соёлын өвүүд илэрвэл | Шаардлагатай тохиолдолд дурсгалуудыг шилжүүлэх | - | - | - | 2025 он | Соёлын өвийг хамгаалах тухай хууль |
| Нийт | | | | | | УАЗ | | |

## 1.18 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

*Хүснэгт 12. Осол эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргээх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний, цар хүрээ | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Баримтлах хууль, журам, стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. Хөдөлмөр хамгаалал | | | | | | | | |
| 1 | үер | Түр кэмп, хөрсний овоолго, тоног төхөөрөмж, барилгын материалын агуулахыг үерт өртөхөөргүй газарт сонгож байршуулах, | Төслийн талбай | - | Үйл ажиллагааны зардалд | Үйл ажиллагааны зардалд | 2025 он | Усны тухай хууль |
| 2 | | Гамшиг эрсдэлийн үнэлгээ боловсруулж холбогдох байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх | | - | Үйл ажиллагааны зардалд | Үйл ажиллагааны зардалд | 2025 он | Гамшгаас хамгаалах тухай хууль |
| 3 | Цасан болон шороон шуурга | Хур тунадас орж халтиргаа гулгаа үүссэн тохиолдолд халтиргаа арилгах бодис, элс, давс цацах арга хэмжээг авах. Элсийг аль болох халтиргаа арилгахад хэрэглэхээс татгалзах нь зүйтэй. Учир нь элс нь хайлахгүй, алга | Төслийн талбай | - | - | Үйл ажиллагааны зардалд | 2025 он | Эрсдэлийг бууруулах арга хэмжээ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | болохгүй учир зам дээр үлддэг сайн талтай. | | | | | | |
| 4 | | Салхи шуурга ихтэй хавар болон намрын улирлуудад замын тоос дарах усалгаа, арчилгаа хамгаалалтын ажлыг ердийн үеийнхээс багадаа 2 дахин нэмэгдүүлэн гүйцэтгэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх. | Төслийн талбай | - | - | Үйл ажиллагааны зардалд | 2025 | А/301 аргачилсан зааврын дагуу |
| 5 | | Бүх ажилчид найдвартай утсан болон цахилгаан холбоотой байх. | Төслийн талбай | 32 | ш | Үйл ажиллагааны зардалд | 2025 он | |
| 6 | Газар хөдлөлт | Газар хөдлөлтийн үед цугларах цэг тогтоож, самбар байршуулах | Төслийн талбай | | | 100.000₮ | 2025 он | Гамшгаас хамгаалах тухай хууль |
| 7 | | Онцгой байдлын үед гамшгаас хамгаалах арга хэмжээ авах талаарх сургалтад ажилчидыг хамруулах | Уурхайн ажилчид | | | 300.000₮ | 2025 он | |
| 8 | Гал түймэр | Ажилчдын түр кэмпэд галын пункт байгуулж гал унтраах багаж төхөөрөмжөөр хангах. | | | | Үйл ажиллагааны зардалд | 2025 он | Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль |
| 9 | | Гал түймрийн аюултай тоног төхөөрөмжийг тавигдаж буй шаардлагын түвшинд стандартын дагуу тусгаарласан өрөө, ил талбайд байрлуулах | | | | Үйл ажиллагааны зардалд | 2025 он | |
| 10 | | Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах | | | | 300.000₮ | 2025 он | |
| 11 | Бусад | Газар шорооны ажил идэвхтэй явагдаж буй цэгийг тойруулан хамгаалалтын хашлага татаж анхааруулах тэмдэг байрлуулах | | | Үйл ажиллагааны зардалд | Үйл ажиллагааны зардалд | 2025 оноос | |
| 12 | | Ажиллагсдыг ХХАА-ны хувцас хэрэгсэл буюу бээлий, | | | 1.000₮ | 1.000₮ | 2025 оноос | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | малгай чихний бөглөөс болон бусад хамгаалах хэрэгслээр бүрэн хангах, хэрэглүүлж хэвшүүлэх | | | | | | |
| 13 | | Ажилчдад анхан шатны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх, анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг хяналтын өрөө эсвэл ажлын байранд ил харагдахаар газарт байрлуулах | | | Үйл ажиллагааны зардалд | Үйл ажиллагааны зардалд | 2025 оноос | |
| | | **Нийт** | | | | **1700.0₮** | | |

## 1.19 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 13. Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн үнэлгээ, мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Баримтлах хууль, журам, стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах | Уурхайн талбай болон ажилчдын тосгонд стандартын шаардлага хангасан, ангилан ялгах тэмдэглэгээ бүхий хогийн сав байршуулах | Уурхайн тосгонд Уурхайн талбай | ширхэг | 500.0 | 2 байршилд | 1000.0₮ | 2025 онд | |
| 2 | | Замын-Үүд сумын ЗДТГ-тай Хог хаягдлын гэрээ хийх. | Төслийн хүрээнд | - | - | - | - | 2025 онд | |
| 3 | | Орон нутагтай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээний дагуу ангилан ялгасан хог хаягдлыг холихгүйгээр тээвэрлүүлэх | Төслийн хүрээнд | - | 500.0 | - | 500.0₮ | 2025 онд | |
| 4 | | Ажилчдын бие засах газрыг био оо-р шийдвэрлэх | Төслийн хүрээнд | - | - | Хөрөнгө оруулалтын зардлаар | | 2025 онд | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | | Уурхайн бие засах газар болон хог хаягдлын цэгүүдэд ариутгал халдваргүйжилд хийх | Баруун шанд болон Цагаан чулуутын хэсгийн бие засах газар хаягдлын цэг | | 200.0 | - | 200.0 | 2025 онд | |
| 6 | | Хийсэж тархсан болон үүссэн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж хэвших | Ашиглалтын талбай болон түүний ойр орчимд | - | - | - | ҮАЗ | 2025 онд | |
| 7 | Аюултай хог хаягдал | Ашиглагдсан тос, тосолгооны материал, аккумляторыг тусгай цэг гарган хуримтлуулах | засварын талбайд | - | - | - | 2000.0 | 2025 онд | |
| 8 | | Ашигласан тос тосолгооны материалыг дахин боловсруулах үйлдвэрт улиралд нэг удаа нийлүүлэх, гэрээ байгуулах | Төслийн хүрээнд | | | | - | 2025 онд | |
| | | **Нийт** | | | | | **3700.0** | | |

## 1.20 ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасчаар ЯМААТ” нэртэй хайлуур жоншны ордыг ашиглах далд уурхайн болон баяжуулах үйлдвэр төслийг хэрэгжүүлэхд тухайн орон нутгийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, төсөл хэрэгжиж буй орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулав.

Цаг уур орчны шинжилгээний газрын Байгаль орчны шинжилгээний төв лабораторитой хамтран ажиллах.

*Хүснэгт 14. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр*

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Байршил | Хугацаа давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн өртөг, мян.төг | Нийт зардал, мян.төг | Тайлбар | Баримтлах хууль, журам, стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. Агаарын чанар | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1 | -Тоосжилт (PM10, PSM, PM2.5)<br>-Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин)<br>-Бохирдлын цэгэн эх үүсвэр ($CO_2$, $SO_2$, $NO_2$, CO) | Ажлын байрны дотоод орчин<br>Уурхайн карьер<br>- Технологийн зам | 5 болон 9 сарууддад<br>Үйл ажиллагаа бүрэн хүчин чадлаар ажиллаж байгаа үед | 2 удаа | 165.0 | 330.0₮ | - | “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 |
| 2. Хөрсөн бүрхэвч | | | | | | | | |
| 2.1 | - Ялзмагийн агууламж, pH, давсжилт, чийгшил,<br>NO3-N, P2O5, K2O,<br>pH, нийт азот, нийт фосфор, Cr, Ni, Cu, Pb, Zn, | Уурхайн карьер<br>- Хогийн цэг | 6 сард 9 сард | 2 удаа | 75.0 | 150.0₮ | - | Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019 |
| 3. Усан орчин | | | | | | | | |
| | Ерөнхий ерөнхий химийн үзүүлэлт | Гүний худаг | 5 болон 9 сард | 2 удаа | 50.0₮ | 100.0₮ | - | MNS 0900:2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ |
| 4. Цацраг | | | | | | | | |
| | Цацрагийн шинжилгээ хийлгэх (Гадаад орчин, барилгын материал, уул уурхай, Нийлбэр, Альфа Бета цацраг тодорхойлох ) | - | | 1 удаа | 100.0₮ | 100.0₮ | | |
| | | **Нийт** | | | | **680.0₮** | | |

## 1.21 ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 3. Удирдлага зохион байгуулалтаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь 2024 он | | | Хариусан албан тушаалтан | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сар 1.2.3. | Сар 4.5.6.7 | Сар 8.9.10.11 | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Галын аюулгүй байдлын дүгнэлтийг дүүргийн Онцгой байдлын хэлтсээр гаргуулах | - | 2025 онд | | X | “Гантулга трейд” ХХК | |
| 2 | Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Дотоод төлөвлөлтөөр | 2054 онд | | X | | |
| 3 | Хамгаалалтын захиргаа болон орон нутгийн тавьсан шаардлагыг хэрэгжүүлэх, хамтарч ажиллах | - | - | | | | |
| | Нийт | УАЗ | | | | | |

## 1.22 ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.

*Хүснэгт 15. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө*

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацаа тов | Тайлагнах зардал мян.төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Замын-Үүд, Эрдэнэ сумдын 2 багт | ИНХ-д танилцуулах | Тухайн жилд хийгдсэн ажил | Тухайн оны 4 - р улирал | УАЗ | Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан | Багийн төв |
| 2 | Дорноговь аймгийн Байгаль орчны газар | https://eic.mn/envmng/ буюу Байгал орчны мэдээллийн санд оруулах | Тухайн жилд байгаль орчны талаар хийгдсэн ажил нөхөн | Тухайн оны 11 - р сарын 1 дотор | УАЗ | Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан | Дорноговь аймгийн төв |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сэргээсэн ажлын акт болон холбогдох материал | | | | |
| | Төрийн захиргааны төв байгууллага | https://eic.mn/envmng/ буюу Байгал орчны мэдээллийн санд оруулах, тамгалуулах | | Тухайн оны 12 - р сарын 1 дотор | ҮАЗ | Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан | Төрийн захиргааны төв байгууллага |
| | Нийт | | | | ҮАЗ | | |

# БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

| № | Мэдээллийн төрөл | Нийт зардал мян.төг |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 10050.0₮ |
| 2 | Нөхөн сэргээлтийн зардал | 9000.0₮ |
| 3 | Биологийн олон янз байдал, Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв | 8000.0₮ |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 5 | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 6 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төсөв | 1700.0₮ |
| 7 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв | 3700.0₮ |
| 8 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв | Үйл ажиллагааны зардлаас |
| 9 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв | Үйл ажиллагааны зардлаас |
| 10 | Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв | 680.0₮ |
| | **Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв / Гучин гурван сая нэг зуун гучин мянга/** | **33130.0₮** |